

КОМПАНИЙН НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН **2019**

Агуулга

4	КОМПАНИЙН ТУХАЙ
6	КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА
9	ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД БА ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА
20	АЖИЛЛАГСАД
24	БАЙГАЛЬ ОРЧИН
31	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
34	ШАГНАЛУУД

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг, иймд:

Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинд нэн тэргүүнд анхаарна.

Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монгол Улсад хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг, иймд:

Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорино.

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.

Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй "сайн хөрш"-ийн харилцааг хөгжүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, иймд:

Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.



ЭНЕРЖИ
РЕСУРСЫ

Компанийн тухай

\$1.4 ТЭРБУМ

Ухаа худаг төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалт

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энержи Ресурс компани нь 2005 онд байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай уул уурхайн компани бөгөөд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг. 2010 оны 10-р сард Монголын үндэсний компаниудаас анх удаа Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргасан нээлттэй хувьцаат компани бөгөөд хувьцааны хяналтын багцыг үндэсний хөрөнгө оруулагчид эзэмшдэг.

Бид 2009 оноос Ухаа худагийн хөндийд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж эхэлсэн. Алслагдсан говь нутагт маш богино хугацаанд монгол инженер, техникийн ажилтнуудын хамтын хүчээр нүүрс баяжуулах үйлдвэр болон 18 мегаваттын цахилгаан станц, хатуу хучилттай авто зам, усан хангамжийн систем, 650 айлын орон сууцны хороолол, 700 хүүхдийн багтаамжтай сургууль, цэцэрлэг зэрэг дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж ашиглалтад оруулан, дэлхийн жишигт нийцсэн, уул уурхайн цогцолборыг бий болгосон.

Үндэсний боловсон хүчний нөөц боломжид тулгуурласан бүтээн байгуулалт хийж, үйл ажиллагаа явуулснаар 2,000 гаруй иргэн шууд ажлын байраар хангагддагийн 40 орчим хувийг Өмнөговь аймгийн иргэд бүрдүүлж ирсэн. Түүнчлэн Ухаа Худаг төслийн хүрээнд дотоодын нийт 5,000 гаруй байгууллага, аж ахуйн нэгжтэй туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч хэлбэрээр идэвхтэй хамтран ажиллаж ирсэн байна.

Нийгмийн хариуцлага, байгаль орчин, нөхөн сэргээлтийн бодлого болон орон нутгийн тогтвортой хөгжилд оруулах бидний хувь нэмэр Энержи Ресурс компанийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөний салшгүй хэсгийг бүрдүүлж байдаг.

УУРХАЙН БАЙРШИЛ

- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс 8 км
- Аймгийн нийслэл Даланзадгад хотоос зүүн тийш 90 км
- УБ хотоос өмнө зүгт 540 км

Өнгөрсөн хугацаанд компани нийт нэг 1.4 тэрбум орчим долларыг уурхайн болон дагалдах дэд бүтцийн төслүүдийн хөрөнгө оруулалтанд зарцуулсан төдийгүй улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр 1.4 их наяд төгрөгийг төвлөрүүлсэн.

Энержи Ресурс компани нь нэмүү өртөг шингэсэн, сайн чанарын коксжих нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөн, Монгол Улсын хөгжил, дэвшил, үйлдвэржилтэд бодитой хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

₮330 ТЭРБУМ

ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ (2019)

₮329 ТЭРБУМ

ТАТВАР, ШИМТГЭЛ (2019)

Компанийн нийгмийн
хариуцлага

ISO:26000

Олон улсын нийгмийн хариуцлагын зөвлөмжийн дагуу КНХ-ын бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг.

Энержи Ресурс компани нь олон улсын хөрөнгийн зах зээлд хөл тавьсан хувьцаат компани гэдэг утгаараа компанийн засаглалыг байгууллагын хөгжлийн чухал үзэл баримтлал гэж үздэг бөгөөд хувь нийлүүлэгчдийн эрх ашиг, тэдгээртэй адил тэгш харьцах зарчим болон мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлд онцгой анхаарч ирсэн.

Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь манай компанийн хувьд дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулан, улсдаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол тулгуур хүчин зүйл гэж бид үздэг. Энэ бодлогын хүрээнд дотоодын болон олон улсын сайн засаглалын шаардлага, стандартуудыг мөрдөхийн зэрэгцээ шийдвэр гаргалтын оновчтой, энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэх байдлаар дотоод дүрэм, журмуудын хэрэгжилтийг ханган ажилладаг.

Бид хүний эрхийг дээдэлж, үйл ажиллагааныхаа хүрээнд орон нутгийн иргэдийн болон ажиллагсдынхаа эрхийг зөрчихгүй байх талаар анхаарч ажилладаг төдийгүй хүний эрхийн эрсдлийн үнэлгээг хийж, түүний дагуу хөтөлбөр боловсруулж, сургалт зааварчилгааг холбогдох ажиллагсаддаа тогтмол өгдөг.

Түүнчлэн оролцогч, сонирхогч талуудын итгэлийг хүлээх үүднээс үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид болон бусад төр засаг, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнасаар ирсэн. 2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна.

Компанийн нийгмийн хариуцлагын бодлого, баримтлах зарчим

Энержи Ресурс компани нь компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ыг анхнаас нь бодитой, зөв хэрэгжүүлэхэд анхаарч КНХ-ын бодлого чиглэлээ олон улсын КНХ-ын сайн дурын стандарт болох ISO: 26000-д нийцүүлэн боловсруулсан. Бид КНХ-ын хүрээн дэх бүхий л үйл ажиллагаагаа бодитой судалгаа, тооцоо, менежментийн төлөвлөгөөнд үндэслэдэг бөгөөд тогтвортой, үр дүнтэй эргэх холбоог хэвшүүлэхийг зорьж байна.

2019 онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дэргэд Байгаль орчин, нийгэм, засаглалын асуудал хариуцсан тусгай дэд хороо байгуулагдсан бөгөөд ингэснээр КНХ, байгаль орчин, засаглалын бодлого, стратеги чиглэлүүд, тухайн оны ажлын төлөвлөгөө ТУЗ-ийн түвшинд хянагдан, батлагдах юм. Мөн КНХ-ын чиглэлд аливаа эрсдэл, алдаа дутагдал үүссэн тохиолдолд ТУЗ-өөс санал зөвлөмж өгөх, ахиц сайжралт гаргах, хяналт тавих боломж бүрдэж байна.

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд төслийн үндсэн үйл ажиллагаа хэрэгждэг тул орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, нийгмийн суурь бүтцүүдийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд


дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажилладаг.

Өнөөдөр тус компани нь уул уурхайн салбарын хэмжээнд компанийн нийгмийн хариуцлага хэрэгжүүлэгч шилдэг компанийн нэгээр зүй ёсоор нэрлэгдэж, оролцогч талуудынхаа итгэлийг хүлээн, нийгмийн зөвшөөрлөө ханган, улс орны болон орон нутгийн тогтвортой хөгжилд бодит хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр

УЛСЫН ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР

тэрбум төг



Энержи Ресурс компани нь үйл ажиллагаа эхлүүлснээс хойш татвар төлөлт, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн хэмжээгээр Монгол Улсын Топ 5 аж ахуйн нэгжээр тогтмол шалгарч, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулж ирсэн. Тодруулбал, 2009-2019 он хүртэлх арван жилийн хугацаанд нийт 1.4 их наяд төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Зөвхөн 2019 онд л гэхэд татвар, шимтгэл хэлбэрээр нийт 329 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих нэг хэлбэр нь орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах явдал байдаг. Компанийн зүгээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчмыг баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчдэд давуу эрх олгож, хамтран ажиллахыг нэн тэргүүнд зорьдог.

Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн хүрээнд дотоодын нийт 5,000 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр хамтран ажиллаж ирсэн. Зөвхөн 2019 оны байдлаар нийт 300 орчим аж ахуйн нэгжээс 350 орчим тэрбум төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авсны 94% нь дотоодын аж ахуйн нэгж, компаниуд байсан. Тайлант хугацаанд Өмнөговь аймгийн хэмжээнд орон нутгийн 30 аж ахуйн нэгжээс нийт 8.8 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг.

₮15.1 ТЭРБУМ

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (2019)

50 ТӨСӨЛ

УРТ БА БОГИНО ХУГАЦААНЫ
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД (2009-2019)



Төсөл хөтөлбөрүүд ба
орон нутгийн харилцаа

БОДЛОГО, ЗАРЧИМ

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг мөрдлөг болгож, хүний эрхийг дээдлэх, сонирхогч талуудын идэвхтэй оролцоог хангах, шударга, нээлттэй, ил тод байх зарчмуудыг баримтлан ажиллахыг эрмэлздэг.

Бид үүсэн байгуулагдсан цагаасаа хойш орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлж, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн санал бодлыг төсөл хэрэгжилтийн явцад тусгаж ирсэн бөгөөд жил бүр ойролцоогоор нэг тэрбум гаруй төгрөгийг орон нутгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулсаар ирсэн.

Энэхүү хөтөлбөр, төслийн хүрээнд иргэд, оролцогч талуудтай зөвлөлдөх, компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг түгээх, орон нутгийн иргэд, оролцогч талуудаас ирсэн санал гомдлыг барагдуулахад анхааран ажилладаг. Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд компанийн орон нутагт оруулсан бүхий л хөрөнгө оруулалт нь тус бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, цаашлаад орон нутгийн иргэд төдийгүй компанид ч үр өгөөжөө өгөх зорилго агуулагдаж байдаг.

Оролцогч, сонирхогч талуудын хамтын ажиллагаа

Энержи Ресурс компани нь төслийн үйл ажиллагаандаа оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн урт хугацаанд тогтвортойгоор хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу дараах зарчмуудыг ханган ажилладаг.

- Иргэд, олон нийтийг компанийн үйл ажиллагааны талаар холбогдох мэдээлэл авах эрхийг бүхий л талаар ханган ажиллах;
- Олон нийтийн иргэдийн санал хүсэлтийг “Нээлттэй өдөрлөг” хийх замаар үйл ажиллагаандаа тогтмол тусгах;
- Орон нутгийн иргэдийн оролцоог хангах замаар төрөл бүрийн хэлэлцүүлэг, бүлгийн уулзалт, сайн дурын зөвлөлийг дэмжин ажиллах;
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн зорилтот төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
- Иргэдийн санал, хүсэлт болон өргөдөл гомдлыг мэдээллийн төв болон бусад сувгаар тогтмол хүлээн авах;

Орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл (ОНЗ) байгуулан тууштай хамтран ажилласаар ирсэн.

НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2009 оноос орон нутгийн нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг зохион байгуулж ирсэн.

Түүнчлэн орон нутгийн иргэдийг байгаль орчны мониторинг, гар худаг болон тоосны хэмжилт, нөхөн сэргээлтийн ажилд сайн дураараа хяналт тавих байдлаар тогтмол оролцуулдаг нь компани ба иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлдөг.

Өргөдөл, гомдол барагдуулах механизм

Орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж эргэн мэдээлэх журам хэрэгжүүлэн ажилладаг. Ингэхдээ өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгч, шаардлагатай болон хүсэлт гаргасан тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалах ба бүх гомдолд ижил тэгш зарчмаар ханддаг.

2019 онд “Иргэд, хуулийн этгээд, сонирхогч талуудын өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, судлан бүртгэх” журмын хүрээнд мэдээллийн төвөөрөө дамжуулан нийт 48 өргөдөл, гомдол хүлээн авч, 30 хоногийн дотор 100% шийдвэрлэсэн. Ингэхдээ 15 өргөдөлд боломжгүй гэсэн хариу өгч, 33 өргөдөлд дурдагдсан асуудлыг компаниас шийдвэрлэж өгсөн. Нийт өргөдлийн 46 нь компанитай хамтран ажиллах болон санхүүгийн болон биет дэмжлэг хүссэн утгатай хүсэлтүүд зонхилж байна. Үлдсэн 2 өргөдөл нь уурхайн төслийн талбайд мал орж гэмтсэнтэй холбоотой гомдол байсан. Тайлант хугацаанд ноцтой гомдол хүлээж аваагүй. Жил ирэх тусам ард иргэдээс ирэх гомдлын тоо багасч, санал хүсэлтийн тоо эрс нэмэгдэж байгаа нь компанийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бодитой хэрэгжүүлж, нээлттэй, олон талт харилцааг хөгжүүлэн ажиллаж ирсэний бодит үр дүн юм.


Орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр

Орон нутгийн тогтвортой хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш Өмнөговь аймгийн Цогтцэций сум буюу Ухаа худагийн хөндийд өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогцоор бүрдүүлсэн. Тухайлбал, Монгол инженерүүдийн ур ухаанаар дулааны цахилгаан станц, усан хангамжийн систем барьж байгуулснаар орон нутгийн иргэд 24 цагийн найдвартай эрчим хүч, цэвэршүүлсэн усаар хангагдах болсон.

Мөн орон сууцны “Цэций” хороолол, сургууль цэцэрлэгийн “Мөрөөдөл” цогцолборыг барьж байгуулснаар ажиллагсад болон орон нутгийн иргэд ая тухтай амьдрах, хүүхэд багачууд говийн алслагдмал суманд ч тохилог орчинд, чанартай боловсрол олж авах нөхцөл боломж бүрдсэн. Түүнчлэн компанийн худалдан авалтын бодлогоо орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглүүлж, Өмнөговь аймгийн ААН,

ОРОН НУТГИЙН ХУДАЛДАН АВАЛТ

тэрбум төг



бизнес эрхлэгчидтэй гэрээлэн ажиллахыг чухалчлан үздэг. 2019 онд л гэхэд орон нутгийн хэмжээнд 30 аж ахуйн нэгжээс нийт 8.8 тэрбум төгрөгийн бараа материал, ажил үйлчилгээний худалдан авалт хийжээ.

Орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтын дүн /2019/

Хөрөнгө оруулалтын чиглэл	/мян.төг/
Орон нутгийн дэд бүтэц	3,356,635
Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	934,659
Хандив, тусламж	1,968,038
Орон нутгийн худалдан авалт	8,800,000
Нийт	15,068,332

НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компани нь орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, төрийн бус байгууллага, засаг захиргаатай хамтран хэрэгжүүлсээр ирсэн.

2010 оноос хойш нийгмийн суурь таван чиглэлээр 50 гаруй жижиг, том төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд Цогтцэций сумын болон нөлөөллийн бусад сумдын нийт 10 гаруй мянган иргэд эдгээр төсөл, хөтөлбөрийн үр дүнг шууд болон шууд бусаар хүртсэн байна.

2019 онд төсөл, хөтөлбөрүүдийнхээ хэрэгжилтийг үргэлжлүүлэн орон нутгийн оролцогч, сонирхогч талуудтай “сайн хөрш”-ийн харилцааг эрхэмлэж, малчдад өвс тэжээлийн тусламж үзүүлэх, сар шинээр өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг уламжлалт ажлуудаа хийж гүйцэтгэлээ. Тайлант онд нийт 15.1 тэрбум төгрөгийг орон нутгийн дэд бүтэц, тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөр болон орон нутгийн худалдан авалт, хандив тусламжид зарцуулсан байна.

2019 оны хувьд компанийн зүгээс нийгмийн хариуцлагын цар хүрээгээ илүү өргөн цар хүрээнд авч үзэж, зөвхөн Өмнөговь төдийгүй үндэсний хэмжээний нийгмийн тулгамдсан эмзэг асуудлуудыг шийдвэрлэхэд бодит хувь нэмрээ оруулан, талуудтай хамтран томоохон хэмжээний төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажилласан нь онцлог байлаа.

Тухайлбал Улаанбаатар хотын агаарын бохирдол, утааг бууруулах хөтөлбөрийг дэмжин ажиллах Монгол Улсын Засгийн газрын саналыг хүлээн авч, бодит дэмжлэг болгон сайжруулсан түлшний түүхий эд буюу Ухаа худагийн угааж баяжуулсан эрчим хүчний нүүрсээр үнэ төлбөргүй хангаж эхэлсэн. Ийнхүү Улаанбаатарын утааг багасгаж, агаарын бохирдлыг бууруулах үйлсэд бодитой хувь нэмэр оруулснаар нийслэлчүүдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдаж байна.

ДАЛАНЗАДГАДАД ДУЛААНЫ СТАНЦ БАЙГУУЛАХ ТӨСӨЛД ХАМТАРНА



Нийгмийн хариуцлагын хүрээнд Даланзадгад суманд шинээр баригдах Дулааны станцын ТЭЗҮ буюу Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах гэрээг байгууллаа. Компанийн зүгээс тус станцын хөрөнгө оруулалтад үе шаттайгаар хамтран ажиллах юм. Даланзадгадын одоо байгаа дулааны станц хуучирснаас доголдол гэмтэл ихтэй, хүчин чадлаа дийлэхгүй болсноос гадна сүүлийн жилүүдэд уул уурхайн бүтээн байгуулалтыг дагаж тус сумын оршин суугчид, орон сууцны тоо эрс нэмэгдсэн. Шинэ дулааны станц ашиглалтад орсноор өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангаж, иргэд таатай сайхан нөхцөлд ажиллаж амьдрах, улмаар агаарын бохирдол буурах зэрэг олон давуу тал бий болох юм.

Мөрөөдөл сургуулийн менежментийг сайжруулах, ялангуяа математик, англи хэлний хичээлийн сургалтыг анхаарах замаар эцэг, эхийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, сурагчдын сурлагийн чанарт ахиц гаргах зорилгоор Цогтцэций суманд Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг 2012 оноос эхлэн хэрэгжүүлсэн.

Тайлант онд бид уг хөтөлбөрөө шинэчилж өргөтгөж, өндөр ур чадвартай багш нарыг урьж, сугаад. mn онлайн програм нэвтрүүлж, бүх багш нарт ажлын үр дүнгийн урамшуулал тооцож олголоо.

Боловсрол судлалын ухааны доктор Д.Батболд, МУБИС-ийн Математикийн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор Б.Сандагдорж нарыг зөвлөхөөр ажиллуулж, математик, мэдээлэлзүйн туршлагатай багш С.Батжаргалтай гэрээ байгуулан нийслэлээс Цогтцэцийд суурьшуулан ажиллуулсан. Энэ бүхний үр дүнд багш нар төдийгүй сурагч, эцэг эхчүүдийн сэтгэл ханамж нэмэгдэх, сурагчдын хичээлийн идэвх сайжрах, математикийн хичээлийн хоцрогдол арилах зэрэг бодитой үр дүнгүүд гарсан. Уг хөтөлбөрт Цогтцэций сумын Ерөнхий боловсролын 2 сургуулийн 2,000 орчим багш, сурагчид хамрагдаж байна.

ОРОН НУТГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



ИРГЭДИЙН ТОГТВОРТОЙ АМЬЖИРГААГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



Хүүгүй, хөнгөлөлттэй зээл олгох замаар орон нутгийн иргэдийн жижиг дунд бизнес, туслах аж ахуйг дэмжих, суурьшсан ажиллагсдын гэр бүлийн гишүүдийн бизнес эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр” зургаа дахь жилдээ амжилттай хэрэгжиж байна. Тайлант онд нийт 14 иргэнд 92 сая төгрөгийн хүүгүй зээл олгож, жижиг дунд бизнесийг нь дэмжлээ. Мөн онд орон нутгийн банкинд байршуулсан зээлийн санг 50 сая төгрөгөөр нэмэгдүүлснээр хөтөлбөрийн цар хүрээ өргөжсөн.

Хөтөлбөрт хамрагдахыг хүссэн иргэд төслийн шалгаруулалтад оролцсоноор 10 хүртэлх сая төгрөгийн зээлийг 3 хүртэлх жилийн хугацаатай хүүгүйгээр авах боломжтой. Өөрөөр хэлбэл компанийн зүгээс иргэдийн зээлийн хүүний төлбөрийг бүрэн хариуцаж, иргэдийг бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэх боломжийг олгодог. Хөтөлбөрт хамрагдагсад хүүгүй зээл олгоод зогсохгүй орон нутгийн “Амжилтын томъёо” ТББ бизнесийн сургалт, зөвлөгөөг тогтмол өгч ажилласан.

Энержи Ресурс компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг тог цахилгаанаар найдвартай хангахын зэрэгцээ бусад сумдад тог цахилгааны доголдол үүссэн үед цахилгаан нийлүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. Дунджаар авч үзвэл, жил бүр 30,000 м³ цэвэршүүлсэн ус, 7 сая кв/ цаг цахилгаан эрчим хүчийг орон нутагт улсын суурь үнээр нийлүүлж, жил бүр нэг тэрбум орчим төгрөгийн зардал гаргадаг байна.

Тайлант онд Даланзадгадын дулааны цахилгаан станц болон Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор, Булган, Хүрмэн, Мандал-Овоо, Номгон, Цогт-Овоо зэрэг нийт 11 сумдад нийт 57,100 тонн буюу 900 сая орчим төгрөгийн өртөг бүхий эрчим хүчний нүүрс үнэ төлбөргүй нийлүүлсэн. Мөн Даланзадгад сумын төвд нүүрсний цэгийг байгуулан хямд, чанартай нүүрсээр айл өрхүүдийн хэрэгцээг хангаж байна.

Түүнчлэн сүүлийн 10 жилийн турш малчдад өвс, тэжээлийн тусламж үзүүлж ирсэн. 2019 онд Ханбогд, Ханхонгор, Цогт-Овоо, Баян-Овоо сумдын өвсний фонд болон 400 малчин өрхөд нийт 9,000 боодол өвс, 45 тонн хивэг тэжээл хандивлалаа. Мөн сар шинийн баяраар орон нутгийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд туслалцаа үзүүлэх ажлуудыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

“САЙН ХӨРШ” ХӨТӨЛБӨР

30,000 М³

Ундны цэвэршүүлсэн ус

7 САЯ КВ/ЦАГ

Цахилгаан эрчим хүчийг жил тутам орон нутагчт үнэгүй нийлүүлдэг

“АМРАЛТААРАА АЖИЛЛАЯ” ЗУНЫ ХӨТӨЛБӨР



Цогтцэций, Ханхонгор, Баян-Овоо, Цогт-Овоо сумын оюутан залууст амралтаараа ажил эрхлэх, нэмэлт орлого олох боломж олгох, улмаар тэдгээрийг хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Амралтаараа ажиллая” хөтөлбөрийг 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүллээ.

Хөтөлбөрийн хүрээнд зуны турш Ухаа худаг уурхайн 11 алба хэсэгт нийт 42 оюутныг мэргэжлийн чиглэлийн дагуу дадлагажуулж ажиллуулсан. Цогтцэций, Баян-Овоо сумдын 22 оюутан Ухаа худаг төслийн мод үржүүлгийн талбай, оффис, төслийн нэгжүүдэд ажиллаж, ажил хөдөлмөрийн туршлага хуримтлуулсан бол Ханхонгор, Цогт-Овоо сумдын 20 оюутан сум, орон нутгийнхаа ногоон байгууламж бүтээн байгуулалтад өөрсдийн хувь нэмрээ оруулан ажилласан байна.

ОЙН ЗУРВАС ТӨСӨЛ

Орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд өрхийн орлогыг нэмэгдүүлэх, газар тариалан эрхлэлтийг дэмжих урт хугацааны бодлогоор ойн зурвас байгуулж, газар тариалангийн төсөл хэрэгжүүлдэг. “Ойн зурвас” төсөлд маань орон нутгийн иргэд болон шилжин суурьшсан ажиллагсадын гэр бүлийн гишүүд хамрагдаж, өрхийн бизнесээ сайжруулсаар байна. 2019 онд 8 га талбайд Цогтцэций сумын 6 албан байгууллага, 46 өрх төмс, хүнсний ногоо тариалж, 40 орчим тонн ургац хураан авлаа. Уг талбайгаас хураан авсан төмс, хүнсний ногоо нь орон нутгийн хүнсний ногооны зах зээлийн тодорхой хувийг бүрдүүлж байна.



“УХАА ХУДАГ НААДАМ – 2019”



Соёлын өвийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн иргэдэд хүндэтгэл үзүүлэх, уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Ухаа худаг” наадмыг жил бүр зохион байгуулж ирсэн. “Ухаа худаг-2019” наадмыг Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумдыг хамруулан Цогтцэций суманд зохион байгуулсан.

Наадамд хүчит 128 бөх, өсвөрийн 32 бөх барилдаж, таван насны хурдан морины уралдаан болж, халх сурын харваанд 133 эрхий мэргэн харваачид цэц мэргэнээ сорьсон. Мөн Цогтцэций, Ханбогд, Ханхонгор сумын сурагчид, аймгийн ХЖТ-ын уран бүтээлчид гээд нутаг нутгийн авьяастнууд түүх, соёлын баялаг уламжлалтай говь нутгийнхаа өв соёлыг сурталчлан таниулав.

2019 онд компанийн зүгээс “Эрүүл үрс, гэрэлт ирээдүй” ТББ-тай хамтран говийн бүсийн аймгуудын хүүхдийн эрчимт эмчилгээний тасгуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах 370 сая төгрөгийн төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

Уг төслөөр Говьсүмбэр, Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгуудын хүүхдийн тасгууд нярайн шарлагын аппарат, инкубатор, дуслын аппарат, билиметр гэх мэт нэн шаардлагатай, төсвөөс олдоц, хүрэлцээ муутай байдаг тоног төхөөрөмжүүдээр хангагдсан. Төслийг хэрэгжүүлэхдээ эмнэлэг тус бүрээс урьдчилсан судалгаа авч, бодит хэрэгцээнд нь тулгуурласан тоног төхөөрөмжүүд нийлүүлсэн. Тухайлбал Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нярайн тасагт чухал шаардлагатай байсан, 88 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжүүдийг хандивласан. Уг төслийн үр дүнд барагцаагаар жилд 7,000 орчим хүүхдэд очих эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмж сайжрах тооцоолол гарсан.

ГОВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫГ НЯРАЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАВ



ОРОН НУТАГ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ХОГНЫ МАШИНУУДАЙ БОЛЛОО



Орон нутгийг дэмжих “Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд Хюндай маркийн 4 тоннын даацтай бүрэн гидр системтэй, хог ачих, өөрөө буулгах, нягтаршуулах автомат тусгай зориулалттай 9 автомашиныг Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Ханхонгор сумд болон Паблик сервис ХХК-д тус тус хүлээлгэн өглөө. Орон нутгийн орчны тохижилт болон хог хаягдлын менежментийг сайжруулах үйлсэд бодит хувь нэмэр оруулах зорилгоор уг машинуудыг хандивлалаа.

Зүрхний төрөлхийн гажигтай, амьжиргааны боломж тааруу нийт хүүхдүүдэд амьдрал бэлэглэх “Бяцхан зүрх” төслийг Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 40 хүүхдийн эмчилгээний зардлыг иж бүрэн дааж, БНХАУ-д мэс засалд оруулан эмчлэх бөгөөд үүнд шаардагдах 920 сая төгрөгийн санхүүжилтийг хандивласан.

Төсөлд хамрагдах хүүхдүүдийг сонгон шалгаруулах, эмчилгээ, хяналт зэрэгт Шастины нэрэмжит III эмнэлгийн зүрхний мэс заслын эмч, мэргэжилтнүүд хамтран ажиллаж буй бөгөөд байнгын эмнэлгийн хяналтанд байдаг хүүхдүүдээс сонгосон бөгөөд Монголд эмчлэх боломжтой эсэх, амьжиргааны түвшин зэргийг харгалзаж үзсэн.

ЗҮРХНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН “БЯЦХАН ЗҮРХ” ТӨСӨЛ




ЗХЗ САГСАН БӨМБӨГИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН АЛБАН ЁСНЫ ТҮНШ




Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх, олон улсад амжилт гаргах боломжийг дэмжих үүднээс ЗхЗ сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багуудыг албан ёсоор дэмжин ажиллаж байна. Ингэхдээ Монголд анх удаа ЗхЗ сагсан бөмбөгийн багуудыг клубын зохион байгуулалтанд оруулсан бөгөөд гадаадад тэмцээн уралдаануудад тасралтгүй оролцож, Олимпын оноо цуглуулах, дотооддоо бэлтгэл сургуулилалтаа тасралтгүй, сайн хийх боломжийг бүх талаас бүрдүүлэн ажиллаж байна. Цаашид өсвөр залуу үеийнхнийг багийн спортоор хичээллэх боломжийг нэмэгдүүлэх, жигд хамруулах үүднээс дотооддоо цуврал тэмцээнүүдийг зохион байгуулах, мэргэжлийн багуудыг чадавхижуулах чиглэлд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.


ҮНДСЭН АЖИЛЛАГСАД



ЭМЭГТЭЙ АЖИЛЛАГСАД



ОРОН НУТГИЙН АЖИЛЛАГСДЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Ажиллагсад



БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компани нь манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрдөхийн зэрэгцээ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг дагаж биелүүлдэг.

Бид сонгон шалгаруулалтын нээлттэй бодлого баримталдаг бөгөөд ямагт шинийг эрэлхийлэгч, багаар ажиллах чадвартай, байгууллагын соёлд дасан зохицох чадвар бүхий хэн бүхэнд ажил олгохдоо таатай байдаг. Компанийн зүгээс нүүрсний зах зээлийн харьцангуй тогтвортой байдалтай уялдуулан ажлын байр нэмэгдүүлэх, тэр дундаа орон нутгийн иргэдийг ажил, орлогоор хангах чиглэлд нэн тэргүүний ач холбогдол өгч, 2019 онд нийт 800 ажлын байр шинээр бий болгоод зогсохгүй шинэ бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгчдээр хүрээгээ тэлсээр байна.

2019 оны 12-р сарын байдлаар тус компани нийт 2,096 үндсэн ажиллагсадтай байсны 40%-ийг орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумын иргэд зонхилон бүрдүүлж байна. Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамжийн хэлтсээс 2019 онд орон нутгийн 226 иргэнийг ажлын байраар хангасан тул “Шилдэг ажил олгогч байгууллага”-ын өргөмжлөл олгосон.

Ажлын байр, тэгш боломж

Бид хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдынхаа эрхийг дээдэлж, ижил тэгш боломжоор хангахыг зорьдог. Ажилтан, ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа ажил горилогсдын мэргэжил, ур чадварын түвшинг эн тэргүүнд харгалзан үзэхээс гадна орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлд онцгой анхаарал хандуулж ирсэн.

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харъяалал зэргээс үл хамаарсан цалин, хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин, туршлага болон зэрэг, дэв зэргээс хамаардаг.

Тайлант онд нийт ажиллагсдын 13%-ийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлсэн бөгөөд тэдгээрийн 14% нь менежер болон удирдах түвшинд ажиллаж буй нь дотоодын төдийгүй олон улс дахь уул уурхайн салбарын дунджаас дээгүүр үзүүлэлт юм. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах ажлын хүрээнд хүнд машин механизмын операторын

мэргэжил олгох сургалтанд хамруулдаг. Ажиллагсдыг насны ангиллаар нь авч үзвэл нийт ажиллагсдын дийлэнхи буюу 62%-ийг 30-50 хүртэлх насныхан, 32%-ийг 30 хүртэлх насныхан бүрдүүлж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй 70 гаруй иргэдийг ажлын байраар хангаж тогтмол орлоготой байхад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Ингэснээр хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нийт ажиллагсдын 4 ба түүнээс дээш хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохицуулалтыг ханган ажиллаж байна.

Нийгмийн халамж

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн халамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Бид нийт ажилтнууддаа орон сууц худалдан авахад нь банкны хөнгөлөлттэй зээл олгох, даатгал, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэр бүлээрээ нүүн суурьшиж буй ажилтнуудын гэр бүлийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, мөн ажиллагсдын хүүхдүүдийн сургууль цэцэрлэгийн асуудлыг шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллагсдын нийгмийн асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулсаар ирсэн. Түүнчлэн шилжин суурьшсан ажиллагсдын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд 2019 оны байдлаар 354 ажилтан бүртгэгджээ.

Шилжилт хөдөлгөөн

2019 онд шинээр 800 хүнийг ажлын байраар хангасан бөгөөд ингэснээр ажиллагсдын шилжилт хөдөлгөөний жилийн үзүүлэлт 8%-тай байна. Ажиллагсдын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байдаг нь компанийн зүгээс ажиллагсдынхаа нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогоо хэвээр хадгалан, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлсний үр дүн юм.

Тайлант хугацаанд орон сууцны Цэций хороололд 16 ажилтныг, Уурхайчин хороололд 44 ажилтныг гэр бүлийн хамт тус тус суурьшуулсан. Тогтвортой ажиллах гэрээний үүргээ биелүүлсэн 35 ажилтанд орон сууц, 33 ажилтанд хашаа газрын өмчлөлийг үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн байна. Компанийн нийт ажилтнуудын 40% нь тогтвор суурьшилтайгаар 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа нь компанийн зүгээс ажилтнууддаа ижил, тэгж боломжоор хангаж ирсний үр дүн юм.

Тайлант онд "Байгууллагын соёлын судалгаа"-г уурхайн 1,442 ажилтнаас авсан бөгөөд компанид 6 сараас дээш хугацаагаар ажиллаж буй ажилтнууд хамрагдсан. Уг судалгааны үр дүнгээс харвал, ажиллагсдын 93 хувь нь эрхэлж буй ажилдаа болон компанидаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна.

Сургалт хөгжил

Компани байгуулагдсан цагаас эхлэн мэргэжилгүй иргэдийг уул уурхайн чиглэлээр мэргэшүүлж, ажлын байраар хангах, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Ажиллагсдын сургалт, хөгжлийн төлөвлөгөөг албан тушаал бүрийн онцлогийг тусгасан ур чадварын матриц боловсруулан, ур чадварын үнэлгээнд үндэслэн зохион байгуулан ажиллаж байна. Ур чадварын үнэлгээгээс ажиллагсдын ерөнхий болон мэргэжлийн ур чадварын сургалтуудыг төрлийг тодорхойлдог.

Тайлант онд ерөнхий ур чадварын болон нарийн мэргэжлийн нийт 60 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 16,171 ажиллагсдыг хамруулсан нь өнгөрөгч оныхоос 0.6 хувиар хувиар өссөн үзүүлэлт юм. Тодруулбал 1,233,539 хүн/цаг сургалт явагдсан бөгөөд нэг ажилтанд дунджаар 6 цагийн сургалт ногдож байна. Давхардсан тоогоор нийт 1,582 эмэгтэй ажиллагсдыг сургалтанд хамруулсан байна.

Ажилтнуудад зориулсан эрүүл мэндийн хөтөлбөр

Нийгмийн хариуцлагын хүрээнд бид нийт ажилтнуудынхаа бие бялдар, оюун санааны хөгжилд анхаарлаа хандуулж, тэдний эрүүл мэнд, ажил, амьдралын тэнцвэрийг хангахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлээ. Уг хөтөлбөрийг 2018 оноос эхлэн гурван жилийн хугацаатайгаар ажилтнуудынхаа дунд сайн дурын оролцооны хэлбэрээр эхлүүлсэн бөгөөд өнөөдрийг хүртэл 500 гаруй ажилтан дараах арга хэмжээнд хамрагджээ.

- Эрүүл мэндийн иж бүрэн шинжилгээ
- Ажлын байран дахь эрүүл, зөв хооллолтыг дэмжих
- Эрүүл мэндийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалт
- Эрүүл хоол, амьдарлын хэв маягийн талаар мэдээлэл, туршлага солилцох
- Төрөл бүрийн спортын уралдаан тэмцээн
- Фитнесс төв, спортын талбайнуудыг шинээр байгуулж, тохижуулах

Эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдсан ажилтнуудын дунд судалгаа хийхэд 80% нь уг арга хэмжээнд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, цаашид уг хөтөлбөрт үргэлжлүүлэн хамрагдах хүсэлтэй гэсэн байна.

A close-up photograph of a hand holding a green plant branch with small white flowers. Water droplets are falling around the plant, creating a misty effect. The background is a soft, out-of-focus green.

30% ӨСӨЛТ

УСНЫ ДАХИН АШИГЛАЛТ (2019)

110% ӨСӨЛТ

ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТ (2019)

Байгаль орчин

БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компани нь Ухаа худаг төслийн бүхий л үе шатанд байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчныг хамгаалах багц хууль, стандартууд, Олон улсын стандартыг даган мөрдөж, үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилладаг.

Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (БОХАБЭА)-н хүрээнд олон улсын ISO 14001:2004 “Байгаль орчны удирдлагын тогтолцоо” болон OHSAS 18001:2007 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо” стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн удирдлагын тогтолцоо нь БОХАБЭА-н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем тул компаниас хэрэгжүүлж буй бүхий л төсөл, үйл ажиллагаанд хүрч мөрдөгддөг. Бид нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц зэрэг гол бүтээн байгуулалтууддаа говийн нөхцөлд тохирсон байгаль орчинд ээлтэй технологийг ашигладаг.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын шаардлагад нийцүүлсэн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг Ухаа Худаг төсөл эхлэхээс өмнө хийж гүйцэтгэн, төслөөс үүдэлтэй байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөө боловсруулсан. Энэ хүрээнд Ухаа Худаг уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл, эвдрэл, нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн.

2019 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд Ухаа Худаг төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцтэй байдлыг 94% буюу хангалттай хэмээн үнэлсэн. Мөн тайлант онд байгаль орчны ослын тохиолдол бүртгэгдээгүй. Байгаль орчин, ХАБЭА-н талбай дахь ослын тоо болон түүнтэй холбоотой давтамжийн түвшин буурсан нь “Ослыг тэглэх алсын хараа” зорилтыг ханган ажиллаж байгаатай холбоотой.

Байгаль орчны багаас говь нутагт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 2009 оноос хойш нийт 100,000 гаруй мод тарьж ургуулснаас 2019 онд 13,800 мод, сөөгний суулгац тарьсан бөгөөд нийт модны амьдралт 85%-иас дээш байна.

Онцлох ажил:

- Ус олборлолтын хэмжээ өмнөх оноос 11%-р буурч, үйлдвэрлэлд дахин ашиглах усны хэмжээг өмнөх жилээс 30% нэмэгдүүлэв.
- Үерийн хуримтлагдсан усыг цуглуулж, тусгай аргаар тунгаан нийт 30 гаруй мянган тонн усыг үйлдвэр, уурхайн хэрэгцээнд ашиглав.
- Шинэ нэр төрлийн хог хаягдлыг ангилан ялгалтын санаачлага ба бусад хаягдлын ангилан ялгалтыг сайжруулсны үр дүнд дахин боловсруулагдах хог хаягдлын хэмжээ 7%-с 14% болж хоёр дахин нэмэгдсэн.
- Баруун наран уурхайн олборлолтын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг шинэчлэн боловсруулж, БОАЖЯ-аар батлуулав.
- Хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцооллын хүрээнд Score 3-т хамаарах эх үүсвэрүүдээс ялгарах хүлэмжийн хийн хэмжээг шинээр тодорхойлсон.
- Мод үржүүлгийн талбайд сухайны мөчир 2500 ш, бургас 1000 ш, жигд 4000 ш, заг 1000 ш тус тус тарьж бойжуулав.
- Нийтийн эзэмшлийн зам талбайд 2019 онд нийт 2815 ш мод сөөг тарих ажил хийгдсэн байна.
- Хаягдлын овоолгын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж байна.


Усны зохистой хэрэглээ

Энержи Ресурс компани нь олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулдаг үндэсний уул уурхайн компани гэдэг утгаараа хариуцлагатай уул уурхай, тэр дундаа усны менежментийн асуудалд онцгой анхаарал хандуулдаг. Ялангуяа цэвэр усаар хомс говь нутгийн байгалийн онцлогийг дээд зэргээр харгалзан үзэж, усны зохистой хэрэглээг чухалчилдаг.

Ухаа Худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангадаг. Мөн Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг байгуулж, үйлдвэрээс гарч байгаа нүүрсний лаг хаягдлаас усыг шавхан, дахин ашиглаж, үйлдвэрийн усны дахин ашиглалтыг 95 орчим хувьд хүргэсэн. Түүнчлэн цахилгаан станцдаа тусгайлан агаарын хөргөлтийн технологи суурилуулсан учраас Монгол дахь бусад цахилгаан станцуудтай харьцуулахад усыг 4-5 дахин хэмнэдэг.

2019 онд усны менежмент, технологийн горимд сайжруулалт хийснээр үйлдвэрлэлд дахин ашиглах усны хэмжээг 30 орчим хувиар нэмэгдүүлж,

ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН АШИГЛАЛТ



шинээр татан ашиглах усны хэрэглээг 11 орчим хувиар бууруулаад байна. Мөн зун, намрын улиралд үерийн усыг хуримтлуулж, тунгаан ашиглах зэрэг шинэлэг аргуудыг ч туршин хэрэглэж байна.

Хог хаягдлын менежмент

Ухаа худаг төслийн үйл ажиллагааны явцад үүсэх үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг тодорхойлох, хаягдлыг дахин боловсруулах, ангилах, хог үүсэлтийн хэмжээг хянаж бууруулах зорилгоор хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг үүсгэж, сар бүрээр хог хаягдлын мэдээнд анализ хийж хэвшсэн. 2019 онд хог хаягдлын дахин ашиглалтын хэмжээ 14% болж, өмнөх оныхоос хоёр дахин нэмэгдсэн. Ухаа худаг уурхайд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ "3R+R" системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дахиврын цехийг дэргэдээ ажиллуулж, блок, хашаа, сандал, хогийн сав зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тайлант хугацаанд уг цех дээр 14 нэр төрлийн 339 орчим тооны бүтээгдэхүүнийг хаягдал ашиглан хийж зах зээлд нийлүүлсэн. Дахиврын цех дээр хуванцар савыг пресслэгч машин суурилуулснаар 2019 онд 695.5 м3 хуванцарыг пресслэсэн бөгөөд үүний 68.84 м3-ыг хуванцар дахин боловсруулах компанид тушаасан. Мөн төслийн нийт талбайн хэмжээнд их цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэн ажилладаг бөгөөд тайлант хугацаанд зам талбайд тархсан хог хаягдлын цэвэрлэгээг нийт 16 удаа зохион байгуулж, нийт 18,51 м3 хог хаягдлыг цуглуулж төвлөрсөн цэгт хүргүүлсэн.

Агаарын чанар ба шуугианы хэмжилт


Бид төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт болон дуу, шуугианы сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой ажлууд хийж хэрэгжүүлдэг. Тайлант хугацаанд компанийн зүгээс нүүрс олборлох явцын тоосжилтийг бууруулах зорилгоор уурхайн технологийн замын материалыг улаан шавран материалаар хийх, технологийн замыг тогтмол услах, тээвэрлэлтийн хурдыг багасгах, зам усалгааны машинуудын усалгааны төхөөрөмжийг сайжруулах зэргээр ажиллалаа. Мөн дуу, шуугианы эх үүсвэр, түвшнийг тогтмол үнэлж, хянадаг. Цогтцэций сум болон Ухаа худаг уурхай орчим 10 цэгт хэмжилт хийхэд Монгол Улсын стандартаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. Тоосжилтийн нөлөөллийг хянах зорилгоор агаарт агуулагдах нарийн ширхэгт тоосонцор PM2.5 хэмжилтийг Ухаа худаг уурхай, Цогтцэций сум, Цагаан хад зэрэг 15 цэгт хэмжилт хийхэд жилийн туршид дундаж түвшин нь MNS 4585: 2016 стандартын хүлээн зөвшөөрөгдсөн утгаас 0.05 мг/м3-аар бага байв. Мөн хүйтний улиралд уурхайн олборлолтын технологийн замаас үүсэх тоосжилтийг бууруулах тал дээр анхааран ажилладаг.

23 ГА ТАЛБАЙ

2008-2019 оны хооронд
ойжуулсан нийт талбай

ТАРЬЖ УРГУУЛСАН МОД, БУТ

13,800 (2019)



Нөхөн сэргээлт туршилтын талбай

Байгаль орчны нөхөн сэргээлт, орчны тохижилтонд зориулж 2009 оноос эхлэн нөхөн сэргээлт, туршилтын талбайд мод, сөөг үржүүлж бойжуулах, ховор ургамлын үржүүлгийн хэсгээс шилжүүлэн суулгалт хийн ажиллаж байна. Тайлант оны хувьд мод үржүүлгийн талбайд сухайны мөчир 2,500 ш, бургас 1,000 ш, жигдний үр 4,000 ш, заг 1,000 ш тус тус тарьж бойжуулав.

Мөн хаврын тарилтаар 5,300 ш мод сөөгний тарьц суулгац, намрын мод тарилтын үеэр 650 ш суулгац бэлтгэж, гаднаас 3,300 ш мод худалдан авч нийт 9,250 ш мод сөөгний суулгац тарилтанд гаргасан. Мод үржүүлгийн талбайд үржүүлж буй мод сөөгний амьдралтын хувь 80% аас дээш байна.

“Ойн зурвас” төсөл

Цогтцэций суманд байгуулсан “Ойн зурвас” маань жилээс жилд хүрээгээ тэлж, өнөөдөр 20 орчим га талбай бүхий 10 мянга гаруй мод, буттай томоохон төгөл болоод байна. Анх 2011 онд цөлжилтийг бууруулах зорилгоор салхин хаалт болгож уг талбайд 12,000 бут сөөг, мод тарьж байсан. “Ойн зурвас”-ын талбайг цаашид өргөжүүлэх, модны тоо, төрөл зүйлийг нэмэгдүүлэх зорилготой жил бүр тодорхой хэмжээгээр мод тарьдаг. Тухайлбал 2019 онд нийт 1,000 ш хоёр настай заг модыг бортогоор суулгасан нь амьдралын хувь 80%-аас дээш байгаа нь сайн үзүүлэлт юм. Түүнчлэн уг зурваст ногоо тарьж атаршсан газрыг нөхөн сэргээх туршилт хийх зорилгоор 2019 оны 6 сард 0.2 га талбайд таана, хөмүүл, догор зэрэг нутгийн ургамлын 10 кг үрийг тарьж, усалгааны систем суурилуулж усалгааг тогтмол хийв. Тарилт хийснээс хойш нутгийн ургамал тарьсан талбайд үрийн соёололт нийт талбайд 80% орчим бүрхэцтэй ургаж туршилт амжилттай болсон.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах төсөл

Манай компани нь 2009 оноос хойш Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөт ажлын хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх зорилгоор “Цэций хайрхан” ууланд өвс тэжээл, мөс тавих ажлыг жил бүр зохион байгуулсаар ирсэн. Тайлант онд Хангинахын амны уулын туруутан амьтдад зориулж 100кг байгалийн хужир давс болон 200кг өвс, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын Баяндалай сумын нутагт хамаарах нутгуудад 100 боодол өвс тус тус байршуулав. Туруутан амьтдад хужир давс тавьж өгөх нь хаврын улиралд тарга тэвээрэг алдахаас сэргийлдэг. Мөн Говь гурван сайханы цогцолборын захиргаанд амьтдыг ажиглах автомат камерны дэмжлэгийг үзүүлснээс гадна зэрлэг амьтдад зориулсан нарны зайгаар ажилладаг уст цэгийг байгуулж, хүлээлгэн өгсөн. Энэхүү уст цэг нь уулын туруутан амьтдыг амьдрах орчиндоо тогтвортой нутагших, байгалийн ил задгай усгүй үед харангадаж хоргодохоос хамгаалах өндөр ач холбогдолтой юм.

ISO 14001:2015
9001:2015
OHSA 18001:2007

Менежментийн
нэгдсэн тогтолцоо

Сургалт, мэдээлэл

Оролцогч талуудын чухал төлөөлөл болох орон нутгийн иргэдийн байгаль орчны мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургуулийн сурагчид, нутгийн малчид, иргэдэд ойжуулалт, зүлэгжүүлэлт, хог хаягдлын менежмент, байгалийн нөөцийн зохистой ашиглалтын талаар тогтмол сургалт явуулж, мэдээллээр хангадаг. Тухайлбал, тайлант онд “Тэгш дүүрэн” ОНӨААТҮГ-ын ажилчдад хог хаягдлын дахин боловсруулах, орчны тохижилтонд ашиглах, “Цог өрнөх” ОНӨААТҮГ-н ажилчдад эрчим хүчээ хэмнэхийн ач холбогдол, “Мөрөөдөл” сургуулийн багш сурагчдад усны хэрэглээний сэдвээр тус тус сургалт хийсэн.

2019 онд үндсэн ба гэрээт компаниудын ажиллагсдад зориулсан байгаль орчны ерөнхий зааварчилгаанд 2,427 хүн, давтан зааварчилгаанд 3,052 хүн тус тус хамрагдсан. Ухаа худаг уурхайд Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартын Модуль М1, М2 ба М3 сургалт зохион байгуулсан. Сургалтыг олон улсын сургагч зэрэгтэй багш нар удирдан явуулсан бөгөөд стандартыг танилцуулах, хэрхэн хэрэгжүүлэх хэсэгт 44 ажилтан, дотоод аудитор бэлтгэх хэсэгт 25 ажилтан тус тус хамрагдаж, амжилттай төгслөө.

Байгаль орчны дотоод хяналт

Төслийн талбайн ажлын ба ахуйн байрууд дээр хуваарийн дагуу сар бүр ажлын байрны үзлэг хийж, илэрсэн үл тохирлыг тухай бүр залруулах арга хэмжээ авахуулж ажилласан. 2019 онд компанийн дотоод хяналтаар байгаль орчны чиглэлийн 4 хяналтын хуудас ашиглаж шалгалт хийсэн бөгөөд шалгалтын дүнгээс харахад 25 үл тохирол илэрч түүний 13 үл тохирлыг бүрэн залруулж 12 үл тохирлыг залруулах шатанд явж байгаа бөгөөд залруулах хугацаанаас хэтэрсэн үзүүлэлттэй үл тохирол байхгүй байна. Тайлант хугацаанд нийт 5 үндсэн хэлтсийн 36 ажлын байр дээр сар бүр ажлын байрны үзлэг хийсэн бөгөөд байгаль орчин, орчны эрүүл ахуйтай холбоотой нийт 150 үл тохирол илэрсний 94% нь бүрэн арилсан байна.

Хамтын оролцоотой мониторингийн ажлыг тогтмолжуулснаар компани болон орон нутгийн иргэд бусад оролцогч талуудын харилцан итгэлцэл нэмэгдэх, бүх оролцогч талууд нэг ойлголттой болох зэрэг чухал ач холбогдолтой юм.

Хөндлөнгийн хяналт мониторинг

Орон нутгийн иргэдэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулах, байгаль орчны хээрийн хэмжилтэнд иргэдийг оролцуулах, хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд өгөх зорилготой сургалт, танилцуулгын ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн. 2019 онд хамтын оролцоотой орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт орон нутгийн нийт 100 орчим иргэн оролцож хяналт тавьлаа. Тодруулбал, Цогтцэций сумын

төрийн байгууллагын ажилтнууд, малчид, “Цэций” хорооллын оршин суугчдын төлөөлөл зэрэг иргэд, олон нийтэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулж, худгийн усны болон тоосны хэмжилтийг газар дээр нь хийж үзүүлэн, хэмжилтийн бодит үр дүнг танилцуулсан.

Ийнхүү хамтын оролцоотой мониторингийн ажлыг тогтмолжуулснаар компани болон орон нутгийн иргэд, бусад оролцогч талуудын харилцан итгэлцэл нэмэгдэх, бүх оролцогч талууд нэгдсэн ойлголтонд хүрэх чухал ач холбогдолтой юм.

26% БУУРАЛТ

НИЙТ ОСОЛ ГЭМТЛИЙН ДАВТАМЖ

"0"

НОЦТОЙ ОСОЛ ГЭМТЭЛ



**Хөдөлмөрийн
аюулгүй байдал**

93%

Хууль, стандартын
нийцэл (2019)

БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Ухаа худаг төслийн хүрээнд олон улсын 'ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцоо' болон 'OHSAS 18001:2008 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага удирдлагын тогтолцоо' стандартуудын шаардлагын дагуу БОХАБЭА удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажилладаг.

Нүүрс баяжуулах үйлдвэртээ Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо OHSAS 18001:2007 гэсэн олон улсын гурван төрлийн стандартаар Менежментийн тогтолцоог Монголдоо анх удаа нэвтрүүлсэн. Ингэснээр бүтээгдэхүүний чанар, үйл ажиллагааны бүтээмжийн чиглэлд ахиц гаргаж, олон улсын жишгийг эх орондоо нутагшуулсан юм.

Үйл ажиллагаа

Энержи Ресурс компанийн хэмжээнд “Ослыг тэглэх алсын хараа” зорилтыг дэвшүүлэн ажилладаг. Энэхүү зорилт болон компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн системд үндсэн ба туслан гүйцэтгэгч компаниудын 4,500 гаруй ажиллагсад бүрэн хамрагддаг. Бид 2018 онд Монголдоо анх удаа Олон улсын стандартын дагуу Менежментийн нэгдсэн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд тайлант онд энэхүү цогц тогтолцоог нэвтрүүлэхийн тулд компанийн 200 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг жил гаруй хугацаанд ажиллаж 90 гаруй дүрэм журманд шинэчлэл хийж, батлууллаа.

2019 онд ноцтой осол гэмтэл гараагүй, Нийт осол гэмтлийн давтамж өмнөх оныхоос 26%-иар буурсан үзүүлэлттэй байна. Үүнд осол бууруулах SMART.TL хөдөлмөрийн аюулгүй байдлын хөтөлбөр болон уурхайн тусгайлсан төлөвлөгөө авч хэрэгжүүлсэн нь эерэгээр нөлөөлсөн.

Гол үзүүлэлтүүд:

- 2019 онд холбогдох төрийн байгууллагаас хийсэн хяналт, шалгалтын хүрээнд ХАБЭА-н үнэлгээ 93% гарсан нь бага эрсдэлтэйд тооцогдох үзүүлэлт юм.
- Нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчдийн ажиллагсад 9.2 сая хүн цаг ажилласан тоон үзүүлэлттэй харьцуулахад хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамжийн үзүүлэлт 0.55, мөн нийт гэмтлийн давтамж 2.41 байлаа.
- Үндсэн болон гэрээт компанийн удирдлагуудыг хамруулан 14 хоног бүр ХАБЭА-н уулзалтыг хийж, гарч буй аюул эрсдэл, ослыг бууруулах, үр дүнтэй арга хэмжээний талаар сайн туршлагаа

9.2

САЯ ХҮН/ЦАГ

(2019)


хуваалцаж байна. Энэ жилийн хугацаанд 40 удаагийн уулзалт зохион байгуулагдаж, нийт 528 ажилтан оролцсон.

- Хүнд машин механизмын операторуудын ядрал, зүүрмэглэлийг хянах хяналтын камерыг нийт 10 өөрөө буулгагч автосамосвалд суурилуулж, хяналтыг уурхайн хяналтын диспетчерүүд хянаж, ядаргааны шинж тэмдэг илэрсэн ажилтнуудын ажлыг зогсоож, шууд удирдлага болон ХАБ-ын менежер ажилтнууд зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан.
- Ухаа худаг салбарын 11 албаны 1,500 ажилтан бүхий 25 нэр төрлийн ажлын байранд “Хөдөлмөрийн эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ”-г хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн.

Сургалт

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ

оролцогсод



Компанийн хэмжээнд хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд “Ослын давтамжийг тэглэх” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд Хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамжийн тоон үзүүлэлтээр тооцож үзвэл тайлант онд энэхүү гүйцэтгэлийн дүн сайн гарсан. Энэхүү гүйцэтгэл нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) –н удирдлагын тогтолцооны олон улсын ангиллын хэрэгжилт дээр тулгуурласан байдаг. Тайлант хугацаанд нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид болон зочид гэх мэт нийт 14,454 хүнд энэ чиглэлийн тусгай материал танилцуулах сургалтыг хүргэж, үүнд нийт 64,486 хүн/цаг зарцуулсан байна.

Хяналт, үзлэг

ХАБ-ын хүрээнд ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлох, нийт ажиллагсдад ХАБЭА-н сургалт зохион байгуулах, ажлын байрны үзлэг тогтмол хийх, зөрчлийг арилгуулах, ослын судалгаа хийх гэх мэт ажлууд компанийн хэмжээнд тогтмол явагддаг. 2019 онд ажлын байрны аюулгүйн үзлэгийг нийт 120 удаа зохион байгуулж, бүх илэрсэн аюул болон үл тохирлуудын шалтгааныг судалж, дутагдал зөрчлийг арилгахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажилласан. Ажилтнууд 3,204 аюулыг мэдээлэх хуудас ирүүлснээс 85%-ийг нь арилгасан үзүүлэлттэй байгаа бол ажлын байрны үзлэгээс илэрсэн 1,458 үл тохирлыг залруулсан байдал 93% байна. Түүнчлэн ажиллагсдад зориулсан ХАБЭА, аюулгүй ажиллагаа, осол, эрсдлийн менежмент, анхны тусламжийн сургалт, зааварчилгаанууд тогтмол хийгдэж байна.

Шагналууд

2019 онд Энержи Ресурс компанийн зүгээс Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмэр болон хариуцлагатай уул уурхайн чиглэлээр явуулж буй үйл ажиллагааг бодитоор үнэлж олон улсын болон төр, засаг, орон нутаг, мэргэжлийн байгууллагууд дараах шагналуудыг олгосон юм.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ОЛОН УЛСЫН ШАГНАЛ



Малайз улсад зохион байгуулагдсан 11 дэх удаагийн Global CSR summit & awards – Компанийн нийгмийн хариуцлагын олон улсын шалгаруулалтад Энержи Ресурс компани нэр дэвшиж, Ази-Номхон далайн бүсийн 200 гаруй компанитай өрсөлдөн, “Орон нутгийг дэмжих хөтөлбөрүүд”-ээрээ Gold буюу ТОП шагналыг хүртсэн. Энэхүү арга хэмжээнд компанийн нийгмийн хариуцлагын тэргүүн туршлагыг хэрэгжүүлэгч дэлхийн томоохон компаниуд шилдэг төсөл хөтөлбөрүүдээрээ өрсөлддөг бөгөөд Энержи Ресурс компани Монгол Улсаа 3 дахь удаагаа төлөөлөн амжилттай оролцоод байна.

МОНГОЛ УЛСЫН ТОП 5 АЖ АХУЙН НЭГЖ

Эдийн засагт оруулж буй хувь нэмрээр манай компани Монгол Улсын ТОП 100 аж ахуйн эхний 5-д дахин эрэмбэлэгдэж, уул уурхайн салбар дахь хувийн хэвшлийн тэргүүлэгч аж ахуйн нэгжийн байр сууриа бататгалаа. Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ хамтран ТОП-100 аж ахуйн нэгжийг эрэмбэлэхдээ компаниудын тухайн жилийн орлого, улсын төсөвт оруулсан татвар, ажиллагсдын тоо, ашиг, хөрөнгийн хэмжээ, нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо гэсэн үндсэн үзүүлэлтийг харгалздаг аж.

АЗИЙН САНХҮҮГИЙН ШИЛДЭГ ХЭЛЦЭЛ



2019 онд ММС буюу Энержи Ресурс компанийн олон улсын зах зээлд гаргасан 5 жилийн хугацаатай, 440 сая ам.долларын бондод дэлхийн санхүүгийн фирмүүд өндөр үнэлгээ өглөө. Тодруулбал Finance Asia фирмээс тус бондыг Country deal of the year буюу Монгол Улсын 2019 оны санхүүгийн шилдэг хэлцлээр нэрлэсэн бол мөн IFR Global болон IFR ASIA фирмээс Ази тивийн 2019 оны санхүүгийн шилдэг хэлцлээр тус тус онцолсон юм. Олон улсын санхүүгийн фирмүүд тухайн жилийн санхүүгийн топ хэлцэл, төсөл, шийдлүүдийг оны эцэст дүгнэн онцолдог уламжлалтай. Тус компанийн гаргасан бондыг үнэлэхдээ “Шинээр хөрөнгө оруулагчдын бааз сууриа тэлж чадсан”, “Зах зээлийн боломжийг сайтар ашигласан” зэргээр онцолсон.



ЭНТРЕПРЕНЁР 2019 - ОНЫ ОНЦЛОХ 10 АЖ АХУЙН НЭГЖ

МҮХАҮТ-ын Танхимын Энтерпренёр шалгаруулалтын Онцлох 10 аж ахуйн нэгжид 10 дахь жилдээ дараалан шалгарч, МУ-ын тэргүүлэгч аж ахуйн нэгжийн байр сууриа дахин баталгаажууллаа. 2019 оны шалгаруулалтад бид улс орны нийгэм, эдийн засагт оруулсан хувь нэмрээр Эрдэнэт үйлдвэр, Оюутолгой компанийн араас ТОП 3-т жагсаад байна. Энтерпренёр нь тухайн жилд улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд хамгийн том хувь нэмэр оруулж, шинийг санаачилсан аж ахуйн нэгжүүдийг нэрлэн урамшуулдаг, жил тутмын шалгаруулалт билээ.

ЧАНАРЫН ШАГНАЛ

Олон улсын ISO стандартуудыг уурхайдаа цогцоор нь нэвтрүүлж, хэрэгжүүлснээрээ Энержи Ресурс компани Монголоос анх удаа чанарын удирдлагын Демингийн шагналыг хүртжээ. Демингийн шагнал нь чанарын удирдлагын дээд шагнал бөгөөд улс, бүс нутаг, тив, дэлхийн хэмжээнд олгодог байна. Бид Ухаа худаг цогцолборын Нүүрс баяжуулах үйлдвэртээ Менежментийн тогтолцоог цогцоор нь Монголдоо анх удаа нэвтрүүлсэн. Ингэснээр бүтээгдэхүүний чанар, үйл ажиллагааны бүтээмжийн чиглэлд ахиц гаргаж, олон улсын жишгийг эх орондоо нутагшуулсан юм.

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ

Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Цогтцэций сумын Засаг Даргын Тамгын Газраас Энержи Ресурс компанийг 2019 оны “Шилдэг ажил олгогч байгууллага”-аар тодруулж батламжилсан.

Түүнчлэн Өмнөговь аймгийн хэмжээнд “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч” байгууллагаар шалгарч, орон нутгийн удирдлагууд өргөмжлөл гардуулсан юм.



Хаяг: Централ тауэр, 16 давхар
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот 14200
Монгол Улс

Утас: +(976) 7012-2279, 7013-2279
Факс: +(976) 11-322279
Цахим шуудан: contact@mmc.mn
Цахим хаяг: www.energyresources.mn

Ухаа худаг, Уурхайчдын хотхон
Цогтцэций сум
Өмнөговь аймаг 46040
Монгол Улс
Утас: +(976) 7712-2304